



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/123

Мандалговь

Г 2018 оны I ээлжийн ЦЭРЭГ ТАТЛАГА Т  
Явуулах тухай

"Батлан хамгаалах тухай хууль"-ийн 17 дугаар зүйлийн 1.4, "Цэргийн албаны тухай хууль"-ийн 12, 13 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн мн/213 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Цэрэг татлагын товчоог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Товчооны даргыг: Ц.Эрдэнэсүрэн - АЗДТГ-ын дарга

Орлогч дарга: хурандаа Б.Амаржаргал - Цэргийн штабын дарга

Нарийн бичгийн дарга: х/ч Г.Цэрэндолгор - ЦШ-ын тоо бүртгэлийн офицер

Гишүүдэд: Х.Жаргал - Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч  
д/х Ш.Гансүх - ЦШ-ын ОНХ, сургалтын офицер

Хоёр. 2018 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг 04 дугаар сарын 18-наас 25-ны өдрүүдэд Луус, Хулд, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Адаацаг, Дэлгэрцогт, Сайнцагаан сумдад зохион байгуулалтын өндөр түвшинд явуулсугай.

Гурав. Цэрэг татлагын товчоонд даалгах нь:

а/. Цэрэг татлагын товчоог тус захирамжийн дагуу тогтоосон хугацаанд зохион байгуулалтын өндөр хэмжээнд ажиллуулан ЗХЖШ-аас өгсөн хяналтын тоог биелүүлэх

б/. Цэрэгт татагдагчдын болон бусад иргэдийн өргөдөл, гомдлыг холбогдох хуулийн дагуу хянан, шуурхай шийдвэрлэх

в/. Цэрэг татлагын үед иргэний үүргээ биелүүлээгүй иргэд, албан тушаалтанд Цэргийн албаны тухай хууль, Зөрчилийн тухай хуулийн дагуу арга хэмжээ тооцож ажиллах

г/. Засгийн газраас тогтоосон хяналтын тоонд багтаан цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэнийг сонгон авах

д/ 1971-1993 оны цэргийн албыг ямар нэгэн төрлөөр хаагаагүй залуучууд болон түүнээс дээш насны залуучуудыг "УИХ-ын 33 дугаар тогтоол"-ын дагуу мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан дүйцүүлэн хаалгах төлбөрийн хэмжээг тооцож мөнгөн төлбөрийг төлүүлэх

е/ Зэвсэгт хүчний Жанжин Штабаас өгсөн хяналтын тооны дагуу гэрээт цэргийг журмын дагуу сонгон авах

ё/ Цэргийн насны залуучуудад "Бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх" талаар авсан арга хэмжээ, сургалт явуулсан тухай тайланг сумдын Ерөнхий боловсролын

0200424

сургуулийн албан бус сургалтын ажилтанаас, урд онуудад цэрэг татлагын товчоогоор орж өвчний улмаас чөлөөлөгдсөн залуучуудын өвчлөл, тэдгээрийг эрүүлжүүлсэн тухай тайланг хүн тус бүрээр сумдын ЭМТ-ийн ерөнхий эмч нараар гаргуулан авах

Дөрөв. Сумдын Засаг дарга нарт даалгах нь:

- а/. Цэрэг татлага явуулах байрыг заавар, журмын дагуу бэлтгэх
- б/. Цэрэг татлагын товчоогоор орох цэргийн насны иргэдэд зарлан дуудах мэдэгдэлийг албан ёсоор хүргүүлж, цэргийн насны залуучуудыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах
- в/. Цэргийн албанд тэнцэгсэдийн анкетан дахь асуултыг үнэн зөв, бүрэн гүйцэд хөтлөх, цэргийн жинхэнэ албанд татагдагчийг холбогдох бичиг баримттайгаар тогтоосон өдөр, цагт цэрэг татлагын байранд бэлэн байлгах
- г/. Цэрэг татлагыг тасалсан, мөнгөн төлбөр төлөөгүй иргэдэд Цэргийн албаны тухай хууль, Зөрчилийн тухай хуулийн дагуу арга хэмжээг авах үйл ажиллагаанд туслалцах

Тав: Цэрэг татлагын байранд ажиллах албан тушаалтнуудыг нэгдүгээр хавсралтаар, цэрэг татлага явуулах хугацааг хоёрдугаар хавсралтаар, зардлын төсвийг эдийн засгийн тооцоонуудын хамт гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Зургаа: "Цэргийн албаны тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 9 дахь заалтыг үндэслэн цэрэг татлагын үйл ажиллагааны зардал 5.288.346 /Таван сая хоёр зуун наян найман мянга гурван зуун дөчин зургаа/ төгрөгийг 2018 оны батлагдсан төсвөөс гарган зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Эрдэнэсүрэнд зөвшөөрсүгэй.

Долоо: Цэрэг татлагын товчооны албан ажлын хэрэгцээнд суудлын автомашин гаргаж үйлчлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Эрдэнэсүрэнд, сумдын цэргийн цэргийн насны залуучуудад нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг хийх бүрэлдэхүүнийг цэргийн штабын захиалгын дагуу унааны хамт гаргахыг Нэгдсэн эмнэлгийн дарга Х.Жаргалд тус тус үүрэг болгосугай.

Найм: Цэрэг татлагын үеэр сумдад болон аймгийн төвд гэмт хэрэг, осол зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулахыг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа М.Ганбаатарт даалгасугай.

Ес: "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн хэрэгжилтийг ханган ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг цэрэг татлагын товчоонд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 48 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



Цэрэг татлагын товчооны байранд ажиллах албан тушаалтан

№	Овог нэр	Албан тушаал	Албан байгууллага
1	Ц.Эрдэнэсүрэн	Цэрэг татлагын товчооны дарга	Аймгийн ЗДТГ
2	хур Б.Амаржаргал	Орлогч дарга	Цэргийн штаб
3	х/ч Г.Цэрэндолгор	Нарийн бичгийн дарга	Цэргийн штаб
4	х/ч Ш.Гансүх	Цэрэг татлагын товчооны гишүүн	Цэргийн штаб
5	Х.Жаргал	Ерөнхий эмч	Нэгдсэн эмнэлэг
6	Ц.Дэлгэрцэцэг	Дотор-Халдварт	Нэгдсэн эмнэлэг
7	Т.Шинэбаяр	Гэмтэл-Мэс засал	-.-
8	П.Цэцэгням	Нүд /хараа, баруун зүүн/	-.-
9	Д.Саранцэцэг	Нүдний сувилагч	-.-
10	Ч.Отгонсүрэн	Шүд	-.-
11	У.Цэрэндэлгэр	Чих, хамар, хоолой / сонсгол, баруун, зүүн /	-.-
12	Б.Ундармаа	Мэдрэл	-.-
13	Ц.Элбэгмаа	Сэтгэц	-.-
14	Ж.Уртнасан	Арьс- Харшил	-.-
15	Б.Одончимэг	Дүрс, оншилгоо	-.-
16	Ш.Шинэбаяр	Жолооч	Нэгдсэн эмнэлэг
17	С.Бямбацэрэн	Жолооч	ЗДТГ

Аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 4 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт




Сумдад цэрэг татлага явуулах хугацаа

№	Сумдын нэрс	Огноо	Эхлэх цаг
1	Луус	2018.04.18	09.00
2	Хулд	2018.04.19	09.00
3	Дэлгэрхангай	2018.04.20	09.00
4	Сайхан-Овоо	2018.04.21, 22	09.00
5	Эрдэнэдалай	2018.04.23	09.00
6	Адаацаг	2018.04.24	09.00
7	Сайнцагаан	2018.04.27	09.00



Аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/196 гуравдугаар захирамжийн гуравдугаар хавсралт



А./ Цэрэг татлагын товчооны сумдад зарцуулах ШТМ-ын тооцоо

Чиглэл	Замын урт (км)	Зарцуулах ШТМ		
		А-92 /20л/	А-92 /18л/	Мобайл
Мандалговь - Луус	55	11	10	
Луус- Хулд	45	9	8.1	
Хулд - Дэлгэрхангай	90	18	16	
Дэлгэрхангай - Сайхан-Овоо	110	22	18.5	
Сайхан-Овоо - Эрдэнэдалай	125	25	22	
Эрдэнэдалай - Адаацаг	115	23	20	
Адаацаг - Дэлгэрцогт	60	12	10.8	
Дэлгэрцогт - Сайнцагаан	45	9	8	
Мандалговь - Эрдэнэдалай – Адаацаг - Мандалговь	320	64	-	
Дотуур ажилд	80	16	-	
<b>Нийт</b>	<b>1045</b>	<b>209</b>	<b>113.4</b>	<b>1+1</b>
ШТМ-ын үнэ аймгийн ШТС-ын ханшаар /төг/	А-92	1790 т	374.110	202.986 т
	Мобайл	7500 т		15000 т
<b>Бүгд</b>			<b>592.096 т</b>	

Б./ Улаанбаатар хотод Цэргийн төв дамжинд цэрэг хүргэхэд зарцуулагдах зардалын тооцоо

№	Чиглэл	Замын урт (км)	Зарцуулах ШТМ	Томилолтын зардал			
			А-92 ( л)	Томилолт	Хоол	Буудал	
1	Мандалговь – УБ-Мандалговь	900	90	1 хүний зардал	16000	19500	
ШТМ-ын үнэ	А-92			1790	Ажиллах хоног	5	5
					Хүний тоо	5	5
<b>Дүн</b>		<b>161.100</b>			<b>400.000</b>	<b>487.500</b>	
<b>Бүгд /төг/</b>			<b>161.100</b>		<b>887.500</b>		
<b>Нийт</b>					<b>1.048.600 Т</b>		

В. Зэвсэгт хүчний 167 дугаар ангид цэрэг хүргэхэд зарцуулах зардалын тооцоо

№	Чиглэл			Замын урт (км)	Зарцуулах ШТМ	Томилолтын зардал		
						А-92 ( л )	Томилолт	Хоол
1	Өмнөговь – ДУ-Өмнөговь			650	65	1 хүний зардал	16000	19500
	ШТМ-ын үнэ	А-92	1790			Ажиллах хоног	2	2
						Хүний тоо	3	3
Дүн				116.350		96000	117000	
Бүгд /төг/					116.350	213.000		
Нийт						329.350 төг		

Г. ЦТТ-ны бүрэлдэхүүний сумдад ажиллах томилолтын зардал

	Сум, орон нутагт	Аймгийн төвд /хоол/
1 хүний зардал	18000	7000
Ажиллах хоног	7	6
Хүний тоо	17	17
Бүгд	2.142.000	714.000
Нийт	2.856.000	

В. / Сумдаас цэргийн албанд тэнцсэн иргэдийг хүргэх шатахууны зардал

№	Сумдын нэр	Хүний тоо	Тээврийн хэрэгслийн марк	ШТМ-ын төрөл	Зарцуулах ШТМ			ШТМ-ын үнэ (төгрөгөөр)		Тайлбар Сумдын ШТС-ын тухайн үеийн ханшаар
					1 км-т зарцуулах (л)	Замын урт км /ирэх, буцах-тайгаа/	Бүгд зарцуулах (л)	Нэгжийн үнэ	Бүгд	
1	Луус		УАЗ-452А	А-80	0,18	100	18	1600	28800	
2	Хулд		УАЗ-452А	А-80	0,18	200	36	1650	59400	
3	Дэлгэрхангай		УАЗ-452А	А-80	0,18	260	45	1700	76500	
4	Сайхан-Овоо		УАЗ-452А	А-80	0,18	452	82	1700	139400	
5	Эрдэнэдалай		УАЗ-452А	А-80	0,18	220	40	1700	68000	
6	Адаацаг		УАЗ-452А	А-80	0,18	208	38	1700	64600	
7	Дэлгэрцогт		УАЗ-452А	А-80	0,18	90	16	1600	25600	
Бүгд						1496	269	462.300		
Дүн (төгрөгөөр)						462.300				